

**АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ
НИЙТИЙН НОМЫН САН**

2022.10.25

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)
				он	Түвшин		
ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ							
Зорилт: 1 Боржигин зан заншил, өв соёлыг түгээн дэлгэрүүлэн							
1	1.1.1 Боржигин түмний өв соёлыг сэргээсэн, ёс заншил, үйл ажиллагааг тусгасан, утга зохиол, уран бүтээлүүдийг туурвихад дэмжлэг үзүүлнэ.		Арга хэмжээний тоо	2021	2	3	<p>“БОРЖИГИН ӨВ СОЁЛ” номноос Боржигины уг гарал, Отог овгууд, Боржигин хошууны үүсэл, Засаг захиргаа, нутаг дэвсгэр, Боржигин хошууны засаг ноёдын шастир, Боржигин хошууны сүм хийд, Боржигин өв соёл гэрэл зургуудаар контент, танилцуулгыг бэлтгэж Говьсүмбэр номын сан цахим хуудсанд байршуулсан. Контенийг 1719 уншигч хандалт хийж үзсэн байна.</p> <p>САР ШИНИЙН БАЯРЫН ӨДӨРТ ЗОРИУЛАН</p> <ul style="list-style-type: none"> • Боржигин идээний ёс уламжлал • Битүүлэх ёсон • Мэндлэх, золгох, шинэлэх, тамхилах ёсон • Хадагтай золгох ёсон <p>зэрэг сэдвээр мэдээлэл бэлтгэн Говьсүмбэр номын сан цахим хуудсанд байршуулсан. 3531 уншигч, иргэд хандалт хийж уншсан байна.</p> <p>Боржигин өв соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд: Эсгий ширмэл урлалын багш Б.Буянжаргалыг урьж анхан шатны сургалтыг зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулиудын 31-н сурагчид хамрагдсан.</p> <p>“Найзуудаа, найзуудаа нааш ир” Зохиолч уншигчдын уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтанд Хүмүүн бичиг сонины эрхлэгч МУСГЗ Б.Элбэгзаяа, Монгол дуу дүрс сак ТББ-ын тэргүүн дипломатич судлаач Б.Баясгалан, МУГБ хүүхдийн элч хөгжмийн зохиолч С.Батболд, ШУА-ын хэл зохиолын хүрээлэнгийн салбарын</p>

						<p>эрхлэгч доктор А.Алимаа нар оролцож хүүхэд багачуудтай номын ярилцлага өрнүүлсэн. 228 хүүхэд багачууд хамрагдсан.</p> <p>Яруу найрагч Жалбуугийн Дансранжав агсны 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд: МЗЭ-ийн болон МСНЭ-ийн гишүүн аймгийн утга зохиолын Боржигидай сэцэн” салбарын удирдах зөвлөлийн дарга Т.Болдбаатар, СГЗ Р.Батжаргал, Ж.Чулуунбаатар нартай ярилцлага хийж Яруу найрагч Жалбуугийн Дансранжав агсаны нэрэмжит гудамж талбай, ажиллаж байсан сургууль, уран бүтээл, зохиолчийн дурсамжаар 2 контент бэлтгэж сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулсан. 2158 иргэд, уншигчид үзсэн.</p> <p>Тал говийн найрагч Ж.Дансранжав-90 эрдэм шинжилгээний хурлыг “Монголын зохиолчдын эвлэл”, “Боржигидай сэцэн утга зохиолын салбар”-тай хамтран зохион байгуулсан. Эрдэм шинжилгээний хуралд 310 хүн хамрагдсан.</p> <p>Шилдэг номын төрөлд шалгарсан МУСГЗ “Боржигидай сэцэн” салбарын зохиолч яруу найрагч Рагчаагийн Батжаргалын “Цагаан хөмсөгт” номыг иргэдэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулсан. 300 ширхэг хэвлэгдэн борлуулагдсан.</p> <p>Хүрсэн түвшин: Арга хэмжээний тоо -7 Хамрагдсан иргэдийн тоо – 7977 Үүнээс: Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо-569 Контентын хандалт-7408 Зарцуулсан зардал- 1,928,716</p> <p style="text-align: center;">Хэрэгжилт 100%</p>
2	1.1.2 Боржигин өв соёлыг түгээн дэлгэрүүлж,					<p>Боржигин түмний өлгий нутаг Говьсүмбэр аймгийн улсын тусгай хамгаалалттай Чойрын Богд уулын байгалийн нөөц газрыг түшиглэн “МОНГОЛ САКУРА” буйлс цэцэглэх цагаар зохион</p>

	залуу үед өвлүүлэх, сурталчилан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулж, хөдөөгийн багийн иргэдэд соёлын явуулын үйлчилгээг үзүүлнэ.		Үйлчилгээний тоо Хамрагдах хүний тоо	2021	1 50	3 73	<p>байгуулагдах түүх соёлын тусгай сонирхлын аялал жуучлалын эвент арга хэмжээнд зориулан:</p> <ol style="list-style-type: none"> 1. Говьсүмбэр аймгийн тухай 2. Монгол сакура 3. Чойрын богд 4. Боржигин нутаг 5. Боржигин морин хуур 6. Боржигин байшин <p>Зэрэг контентуудыг бэлтгэн “Боржигин голомт” жуулчны баазад ирсэн аялагч, иргэд, олон нийтэд 2022.05.13,14-ны өдрүүдэд дэлгэцээр цацаж суртчилан таниулах арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Сүмбэр сумын 4, 5, 6 дугаар багийн малчдад нүүдлийн номын сангийн үйлчилгээг 5, 6 дугаар саруудад 2 удаа зохион байгуулсан. 408 иргэд хамрагдсан. Үйл ажиллагааны үеэр нүүдлийн номын сангийн үйлчилгээг танилцуулан шинэ номын танилцуулга үзэсгэлэн гаргаж, танин мэдэхүйн “АХА” цэнгээнт тэмцээн, С.Буяннэмэхийн нэрэмжит “Таван хором” шүлгийн уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгуулсан.</p> <p>Хүрсэн түвшин: Нүүдлийн номын сангийн үйлчилгээний тоо - 3 Хамрагдсан иргэдийн тоо - 408 Зарцуулсан зардал –217.500 Үүнээс: шатахуун 97500, шагнал 120.000</p> <p style="text-align: center;">Хэрэгжилт 100%</p>
3	1.1.3 Соёл, урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхжуулан,		Сургалтын тоо	2021	1	3	<p>Тус байгууллага нь Удирдах ажилтан-1, Гүйцэтгэх ажилтан-6, үйлчлэх ажилтан-3, нийт 10 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан.</p> <p>Мэргэжлийн боловсон хүчний хангалт 80% байна.</p> <p>Соёлын яам, СИУС-ийн Соёлын дээд сургуулиас зохион байгуулсан Лавлагаа ном зүйн кредит олгох, Дижитал</p>

	<p>орчин нөхцлийг сайжруулж, техник тоног төхөөрөмжөөр хангах.</p>		<p>Хамрагдсан албан хаагчийн тоо</p>	<p>2021</p>		<p>10</p>	<p>маркетингийн мэргэжил дээшлүүлэх цахим сургалтад Арга зүйч Д.Нарнай, Ном зүйч А.Чимэгмаа, Номын санч мэдээллийн ажилтан Б.Аасүрэн, Ш.Түмэннаст, Программист Э.Мажирнамхай нарыг хамруулж чадавхжуулсан.</p> <p>5 албан хаагч 6 өдрийн 30-н төрлийн хичээлийн онлайн сургалтад хамрагдаж шалгалт өгч сертификат авсан.</p> <p>2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр ERP.E-Mongolia.mn цахим сургалтад 7 албан хаагч хамрагдсан.</p> <p>“NEW STORY” хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Соёлын яамтай хамтарсан сургалтад 2 албан хаагч хамрагдаж Говьсүмбэр аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүнээр сонгогдсон.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан ХНУМТ системийн сургалтад 2 албан хаагч, Корнавирист халдвар /ковид-19/-ийн тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам, Манлайллын хэв маяг, хандлага тодорхойлох нь, Алдаа дутагдлыг шийвдэрлэх нь зэрэг сургалтуудад 7 албан хаагч хамрагдсан.</p> <p>Авлигалтай тэмцэх газраас зохион байгуулсан 21 аймгийн шинээр томилогдсон албан тушаалнуудад зориулсан авлигын эсрэг анхан болон дунд шатны сургалтад 7 албан хаагч, Таны эрх таны оролцоо авлигалд үгүй гэж хэлье иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх сургалтад 10 албан хаагч тус тус хамрагдсан.</p> <p>Үндэсний номын сангаас зохион байгуулсан Тогтмол хэвлэлийн улсын нэгдсэн санд орон нутгийн гаргасан тогтмол хэвлэлийг бүртгэж оруулах сургалтад 2 албан хаагч хамрагдсан.</p>
--	--	--	--------------------------------------	-------------	--	-----------	---

						<p>Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс “Харилцаа хандлага ёс зүйн сэдвээр сургалт захиалан авсан.</p> <p>Хууль эрх зүйн хэлтсээс Авлигын тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчлийн тухай хууль</p> <p>Боржигин Өв Музейгээс Угийн бичгийн сургалт зэрэг байгууллагаас болон бусад мэдлэг, чадвар, чадамж нэмэгдүүлэх богино хугацааны сургалтанд албан хаагчдыг хамруулан ажилласан.</p> <p>“-Онцгой байдлын газраас “Галын аюулгүй байдал”, “Хувь хүний хөгжил ба хандлага, сэтгэлгээний өөрчлөлт”, “Амар амгалан Говьсүмбэрийн төлөө”,</p> <p>Аюулгүй байдал хамгаалалтын академ”-ийн хамгаалалтын ажилтан бэлтгэх “Очир” сургалтын төвд 210 цагийн сургалтад 2 албан хаагч хамрагдаж сертификат авсан.</p> <p>Орчин нөхцөлийг сайжруулж техник тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд:</p> <p>Төсвийн хөрөнгөөр: Ном ариутгагч төхөөрөмжийг “Боржигин нутаг BNZ” ХХК-тай гэрээ байгуулан 2,500,000 мянган төгрөгөөр захиалан авч фондын сан хөмрөгийн ном хэвэлэлийг ариутган иргэд, уншигчдад хүргэн үйлчилж байна.</p> <p>Superlead 3300 бар код уншигчийг “Электромон Трейдин” ХХК-аас 330.000 мянган төгрөгөөр худалдан авч уншлага үйлчилгээнд ашиглаж байна.</p> <p>Хөрөнгө оруулалтаар: “Монгол соёл- Монгол хүмүүн” төсөл хөтөлбөрийн хүрээнд 1,932,006 мянган төгрөгийн зөөврийн “DELL core i5” компьютер</p> <p>Хүрсэн түвшин: Сургалтын тоо-18 Хамрагдсан албан хаагч – 10 Зарцуулсан зардал- 400,000 Тоног төхөөрөмжийн тоо- 3</p>
--	--	--	--	--	--	--

							Зарцуулсан зардал- 4,762,006
							Хэрэгжилт 100%
4	1.2.1 Төрийн байгууллагын албан хаагчдыг Монгол бичгийн сургалтад хамруулж, хуучин Монгол бичгээр унших, бичих чадавхыг сайжруулж, албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулж эхэлнэ.		Сургалтын тоо	2021	1	3	<p>Л.Лоохууз багшаар монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтуудыг 3 удаа танхимаар авсан.</p> <p>Говьсүмбэр номын сан монгол бичгийн хичээлийн групп чат нээж өдөр бүр Л.Лоохууз багшаар хичээл заалгаж байна. Албан хаагчдад Монгол бичгээр бичиж, унших дадлага хичээлийг өдөр бүр хийж хэвшсэн.</p> <p>Албан хаагчид монгол бичгээ сурахад Э.Олонцэцэг багшийн гаргасан Үндэсний бичгээ шамдан сурцгаая-1 номыг ашиглаж байна.</p> <p>Монгол бичгийн ахисан шатанд А.Чимэгмаа, Б.Аасүрэн, нар компьютер болон чимээ апп-р ертөнцийн гурав, эрдэнийн сан, субашидаас өдөр бүр бичин суралцаж байна.</p> <p>Байгууллагаас зохион байгуулж байгаа ном уншлагын аян болон цаг үеийн мэдээллийг “Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан” пэйж хуудсанд хос бичгээр бичин байршуулж байна.</p> <p>Монгол бичгийн самбарыг “Уран бичлэг”, “Зүйр онч үгс”, Ойролцоо утгатай үг”, Шинэ мэдээ, мэдээлэл”, “Монгол бичгийн дүрэм” гэж ангилан мэдээллийг Монгол бичгээр мэдээлж, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны бүртгэлийг хос бичгээр бичсэн. Албан хаагчдын өрөөний хаягийг болон энгэрийн тэмдэгийг монгол бичгээр бичсэн.</p> <p>Уншигч, номыг уншиж байгаа хэсэгтээ нугалах, тэмдэглэж муухай болгохоос хамгаалах уншигчдын монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, бататгах зорилгоор “НОМЫН ХАВЧУУРГА”-ыг уншигч, хүүхэд багчууд, иргэдэд зориулан 2 төрлөөр номтой холбоотой зүйр цэцэн үг уриалсан сургамжит мэдээлэл зэргийг монгол бичгээр бичиж бэлтгэн 300 ширхэгийг шинээр ирсэн номонд хийж байрлуулсан.</p>

							<p>Монгол Улсын гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит 19 дэх удаагийн “Бичиг Соёл минь-2022” монгол хэлний бүсийн олипадид Байгууллагын төрөлд хамт олоноороо оролцсон. Ном зүйч А.Чимэгмаа иргэний төрөлд оролцож “Дэд байр” эзэлсэн. Албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулж эхлэх ажлыг эхлүүлэн Архивын Ерөнхий газраас хос бичгийн бланк захиалан авсан.</p> <p>Хүрсэн түвшин: Сургалтын тоо- 3 Хамрагдсан алба хаагчдын тоо-10 Хувь- 100%</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
--	--	--	--	--	--	--	---

Зорилт 5.3: Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган, иргэд, олон нийт мэдээ мэдээлэл, төрийн үйлчилгээг цахимаар авах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

5	5.3.2 Төрийн үйлчилгээнд ХУР, ДАН систем, тоон гарын үсгийг нэвтрүүлж, иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэгдсэн төвийг өргөжүүлнэ.		ХУР, ДАН системд тоон гарын үсгийг нэвтрүүлсэн албан хаагчдын тоо	2021	0	10	<p>2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Төрийн үйлчилгээг цахимжуулах ХУР, ДАН, e-mongolia системийн сургалтанд 7 албан хаагч хамрагдсан. e-mongolia системд 10 албан хаагч бүртгүүлэн ашиглаж байна. Төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын дарга, нягтлан бодогч нар 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр тоон гарын үсэг авсан. 2022 оны 07-08 дугаар саруудад 10 албан хаагч тоон гарын үсэг авч эзэмшсэн.</p> <p>Хүрсэн түвшин: Хур, Дан систем нэвтрүүлсэн албан хаагчийн тоо-10 Тоон гарын үсэг нэвтрүүлсэн албан хаагчийн тоо- 10 Зарцуулсан зардал-50.000</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
6	5.3.3 Төрийн цахим санг өргөтгөн		Цахим сайтад байршуулсан ил тод			12	<p>Мэдээллийн ил тод, байдлыг хангах арга хэмжээнд: Байгууллагын цахим хуудасны шинэчлэлийг засгийн газрын 374-р тогтоолын 9 дүгээр хавсралтын дагуу:</p>

төрийн байгууллагууд аддотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлнэ.	мэдээллийн тоо	2021		10	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал • Хүний нөөцийн бодлогын ил тод байдал • Төсөв, санхүүгийн ил тод байдал • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал зэрэг ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хийлгэсэн. <p>Library.gs.gov.mn цахим хуудсанд 62 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 7798 хандалт авсан байна. Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын сангийн пэйж хуудсанд 461 мэдээ байршуулж, давхардсан тоогоор 11183 иргэд, уншигчид хандалттай.</p>	
	ERP системийг бүрэн нэвтрүүлж, ашиглаж буй албан хаагчдын тоо				10	2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр админ эрх авч байгууллагын 10 албан хаагчдыг бүртгэн ERP системийг нэвтрүүлэн ажиллаж байна.
	Өргөдөл гомдлын тоо				100%	Бичгээр 20 өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Бичгээр хүлээн авсан өргөдөл гомдлоо цахимжуулж ERP системд бүртгэсэн. Цахимаар өргөдөл гомдол, санал хүсэлт ирээгүй болно.
Цахимаар өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн хувь					<p>Хүрсэн түвшин: Цахим хуудас- 62 мэдээ, 7798 хандалт Олон нийтийн сүлжээнд- 461 цахим ном, 11183 хандалт Зарцуулсан зардал- 700.000 ERP системийг нэвтрүүлсэн албан хаагчдын тоо – 10 Хүлээн авсан өргөдөл, гомдлын тоо- 20 Шийдвэрлэлтийн хувь-100 хувь</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>	

Зохицуулалтын салбар					
	Үүнээс		Хугацаа болоогүй	Тасарсан	Биелэлтийн хувь
	Биелсэн	Хэрэгжих шатандаа			

Арга хэмжээн ий тоо		90%	70%	50%	30%	10%	0%		Зохион байгуулалтаас	Хөрөнгийн эх үүсвэр дутагдсанаас	
6	6	-	-	-	-	-	-	-	-	-	100

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
САН ХӨМРӨГЧ, ХҮНИЙ НӨӨЦ

М.АЮУШЖАВ

ХЯНАСАН:
ЗАХИРАЛЫГ ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРНАЙ